



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 05 өдөр

Дугаар А/240

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл балансаас
балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5.1, 5.2-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хавсралтад заасан нийт 694,840,000.00 (зургаан зуун ерэн дөрвөн сая найман зуун дөчин мянга) төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхцэцэг), Нийслэлийн “Төр захиргааны авто бааз” УТҮГ (Э.Болор-эрдэнэ), Чингэлтэй дүүргийн “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв” ОНӨТҮГ (Т.Уламбаяр)-т зөвшөөрсүгэй.

2.Тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу бүртгэн авч, өмчийн ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар (Ж.Алтангэрэл), “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ (Ч.Хувьзаяа), Чингэлтэй дүүргийн “Хайрхан хөгжлийн төв” ОНӨТҮГ (Ц.Баянмөнх)-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110201213



Нийслэлийн Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 05 өдрийн
..... дунд захиралжийн
хавсралт

БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

№	Хөрөнгийн нэр	Марк	Улсын дугаар	Арлын дугаар	Үйлдвэрлэсэн он	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Өмч эзэмшигч байгууллагын нэр	Шилжүүлэх байгууллага
1	Бульдозер тусгай зориулалтын	Liugong CLGB160 CR	62-60 УН	LGCB160CA HC003968	2017	1	315,450,000.00	151,092,308.58	164,357,691.42	"Хот тохижилтын газар" ОНӨААТҮГ	Налайх дүүргийн "Засаг даргын тамгын газар"-т
2	Бульдозер тусгай зориулалтын	Liugong CLGB160 CR	62-65 УН	LGCB160CL HC003969	2017	1	321,890,000.00	171,169,921.96	150,720,078.04	Нийслэлийн "Төр захиргааны авто бааз" УТҮГ	Нийслэлийн "Замын хөдөлгөөн удирдлагын газар" ОНӨТҮГ
3	Суудлын тээврийн хэрэгсэл	Хьюндай акцент	01-48 УБУ	КМНСТ41ВА FU836633	2014	1	34,500,000.00	31,050,000.00	3,450,000.00	Чингэлтэй дүүргийн "Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв" ОНӨТҮГ	Чингэлтэй дүүргийн "Хайрхан хөгжлийн төв" ОНӨТҮГ-Т
4	Микро автобус	Хьюндай старекс	14-15 УНЛ	КМНВН81R ВВU272229	2010	1	23,000,000.00	23,000,000.00	-		
Нийт дүн									318,527,769.46		